

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**САНАМЖ:**

- I. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
II. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариуг сонгоорой.


1. Дэлхийн гадаргыг хавтгай дээр олон дахин багасгаж дүрсэлснийг гэнэ. /1 оноо/

A. Атлас B. Глобус C. Гэрэл зураг
 D. Газарзүйн зураг E. Агаарын зураг

2. Нарны аймагт багтах нарнаас хамгийн хол зайд орших гараг аль нь вэ? /1 оноо/

A. Сугар B. Дэлхий C. Далай ван D. Ангараг E. Буд

3. Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийн үзүүлэлтэд асуултын тэмдгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/



A. Хөдөлмөрийн нөөц B. Боловсролын түвшин C. Ажиллах хүч
 D. Тогтвортой хөгжил E. Амьдралын түвшин

4. 2022 оны эхний хагаст МУ-ын хүн амын 20-30 насны 3000 орчим залуучууд Япон, БНСУ-руу өөрийн хүсэлтээр сурч боловсрох, ажиллах зорилгоор шилжин суурьшсан нь шилжих хөдөлгөөний ямар хэлбэр вэ? /1 оноо/

A. Дотоод шилжих хөдөлгөөн B. Гадаад шилжих хөдөлгөөн
 C. Албадлагын шилжих хөдөлгөөн D. Сайн дурын шилжих хөдөлгөөн
 E. Түр зуурын шилжих хөдөлгөөн

5. Хөдөөгийн байнгын сууринд хамгийн өргөн дэлгэрсэн хэлбэр аль нь вэ? /1 оноо/

A. Тосгон B. Гацаа C. Эдлэн газар D. Том хот E. Жижиг хот

6. Аж үйлдвэрийг байршуулахад нөлөөлөх нийгмийн хүчин зүйлийг сонгоно уу. /1 оноо/

A. Эрчим хүч B. Түүхий эд C. Байршил D. Ажиллах хүч E. Гол мөрөн

7. Хоёр бөхт тэмээ аль бүсэд амьдардаг вэ? /1 оноо/

A. Хүйтэн бүс B. Экваторын бүс C. Сэрүүн бүс
 D. Тропикийн бүс E. Субтропикийн бүс

8. Тунамал чулуулаг аль нь вэ? /1 оноо/


A. Гнейс B. Галт уулын шил C. Гантиг D. Боржин E. Шохойн чулуу

9. Агаарын ижил температуртай цэгүүдийг холбосон шугамыггэнэ. /1 оноо/

A. Изотерм B. Изокол C. Изогипс D. Изобар E. Изобат

10. Далайн урсгалын зурагт 5-ын тоогоор тэмдэглэсэн урсгалыг нэрлэнэ үү.

/1 оноо/




- A. Курсиогийн урсгал
- D. Аляскийн урсгал

- B. Гольфстримын урсгал
- E. Бразилийн урсгал

- C. Саргассын урсгал

11. Биомасс хаана хамгийн их байна вэ?

/1 оноо/






- A. Тундр
- D. Шилмүүс ба навчит ой

- B. Хээр
- E. Субтропикийн ой

- C. Тропикийн чийглэг ой

12. Газарзүйн зургийн хамрах нутгаар нь ангилдаг. Орон нутгийн зургийг сонгоно уу.

/1 оноо/



13. Зургийг ажиглан зөв тодорхойлсон хариултыг сонгоно уу.

/1 оноо/



- A. Растер зураг В. Агаарын зураг С. Вектор зураг
D. Сансрын зураг Е. Аялалын зураг

14. Нарны аймгийн алслагдсан дарааллаар 6 дугаарт байрлах, тэнхлэгээ эргэх хугацаа нь 10 цаг 25 минут бөгөөд 29.5 жилд нарыг 1 бүтэн тойрдог, сансрын биетүүд, тоосонцорын бүслүүртэй гарагийг олно уу. /1 оноо/


- A. Бархасбадь В. Дэлхий С. Ангараг D. Сугар Е. Санчир

15. Чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний олон улсын стандарчилал, импортын татвар хувь хэмжээ, олон улсын мөнгөн шилжүүлэг, онлайн худалдааг илэрхийлсэн даяаршлын хүрээг тодорхойлно уу. /1 оноо/

- A. Эдийн засгийн даяаршил В. Улс төрийн даяаршил С. Нийгмийн даяаршил
D. Соёлын даяаршил Е. Ардчилалын даяаршил

16. Тоон үзүүлэлтийг ашиглан орхигдсон бүс нутгийн хүн амын эзлэх хувийг тооцоолно уу.


/2 оноо/



- A. 17.2% B. 16.2% C. 14.2% D. 15.2% E. 18.2%

17. 2017 оны Катар улсын хүн амын суваргыг ашиглан зөв тайлбарласан хариуг олоорой.

/1 оноо/



- A. 50-59 насны эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс олон
- B. 10-29 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн тоо ойролцоо
- C. 60-с дээш насны эмэгтэйчүүдээс эрэгтэйчүүдийн тоо олон
- D. 0-9 насны эрэгтэй хүүхдийн тоо эмэгтэйгээсээ цөөн
- E. 40-49 насны эмэгтэйчүүдээс эрэгтэйчүүдийн тоо цөөн


18. Органик фермийн тариалангийн талбайн хэмжээгээр тэргүүлэгч Европ тивийн орнуудыг сонгоно уу.

/1 оноо/

- A. Норвеги, Франц
- B. Испани, Итали
- C. Герман, Албани
- D. Итали, Швед
- E. Испани, Латви

19. Тээврийн сүлжээг өргөжүүлэхэд тулгардаг саадуудын нэг нь холбосон туннель, гүүр барих шаардлагатай болдог нь хүчин зүйл юм.

/1 оноо/



- A. Элсэн манханг, харьцангуй
- B. Тэнгис ба буланг, үнэмлэхүй
- C. Уул ба хөндийг, үнэмлэхүй
- D. Уул ба хөндийг, харьцангуй
- E. Шавар ба намгийг, харьцангуй

20. Газарзүйн бүрхэвчийн мөчлөг ба хэмнэлт шинж чанарын онцлогийг тодорхойлсон хариултыг олно уу.

/2 оноо/

- A. Тектоникийн хөдөлгөөн эрчимжих
- B. Өдөр, шөнө ээлжлэх, улирал солигдох
- C. Галт уулын дэлбэрэлтээс тоос нэмэгдэх
- D. Хөрс, ургамал, амьтан тархах
- E. Агаарт чийг өтгөрч үүл бүрэлдэх


21. Салхигүй үед уулархаг газар хүйтэн агаар доошилж, ууландаа дулаан агаар нь үлдэж байгаа үзэгдэл инверсийн ямар төрөл вэ?

/1 оноо/

- A. Агаарын бохирдлын инверс
- B. Хаврын инверс
- C. Цацрагийн инверс
- D. Уулзүйн инверс
- E. Адвекцийн инверс

22. Кипр арал дээр орших Крити нь уулын ямар төрөлд хамаарагдах вэ?


/1 оноо/



- A. Галт уул
- B. Зөрөгт уул
- C. Хөмбөн уул
- D. Атираат уул
- E. Өндөр уул

23. Гадаргын хэлбэрт нөлөөлөх гол хүчин зүйлийг тодорхойлно уу.

/1 оноо/



- A. Газар хөдлөлтийн нөлөө
- B. Салхины нөлөө
- C. Нарны энергийн нөлөө
- D. Усны нөлөө
- E. Мөсөн голын нөлөө


24. ОХУ-ын Иркутск хотод хэддүгээр саруудад хамгийн бага тунадас унадаг вэ?

/2 оноо/




- A. XI-XII сард
- B. III- IV сард
- C. IV-V сард
- D. X-XI сард
- E. II-III сард

25. Тойргон диаграммаар далайн усны бохирдлын хувийг харуулав. Хамгийн бага бохирдуулж байгаа эх үүсвэрийг сонгоно уу. /1 оноо/



- A. Хог хаягдал
- B. Агаарын бохирдол
- C. Хөлөг онгоц
- D. Цутгал гол
- E. Эрэг орчмын уул уурхай

26. Гималайн нуруунд д.т.д 4572 м өндөрт биомассын тархалтад тохирох экосистем аль нь вэ? /1 оноо/



- A. Тундр ба таг
- B. Хуурай хээр
- C. Нуга намаг
- D. Өвстэй тал
- E. Жинхэнэ цөл

27. Ургамал ургахад шаардагдах органик бодисын хэмжээг хөрсний үржил шим гэнэ. Хамгийн бага үржил шимт хөрсийг сонгоно уу. /1 оноо/

A.



Хар шороон хөрс

B.




Нуга, намгийн хөрс

C.



Хээрийн хүрэн хөрс

D.



Цөлийн элсэрхэг хөрс

E.



Голын хагшмал хөрс

28. Сурагч Мөнхөө найзын хамт модон гүүрээр гарч зүүн хойд зүгт аялав. Аялалын төгсгөлд ямар объект таарах вэ? /2 оноо/



- A. Усан цахилгаан станц
B. Гуу жалга
C. Бут ба ой
D. Сайжруулсан шороон зам
E. Жимсний цэцэрлэг

29. “Google Map”-ын газарзүйн зургийг ашиглан Эрдмийн өргөө цогцолбор сургуулиас баруун өмнө зүгт байрлах объектыг нэрлэнэ үү. /2 оноо/



- A. Прогресс зочид буудал
B. 56-р сургууль
C. 114-р сургууль
D. Голомт банк
E. Хөл бөмбөгийн талбай


30. Улаанбаатар хотод өдрийн 12 цаг болж байв. Энэ үед Дубай хотод (III цагийн бүс) хэдэн цаг болж байх вэ? /2 оноо/

- A. 08 цаг
B. 07 цаг
C. 09 цаг
D. 10 цаг
E. 12 цаг


31. Өндөр технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа үйл явцыг тодорхойлно уу. /2 оноо/

- A. Сүүг уламжлалт аргаар боловсруулах
B. Арьс, шир элдэж сур бэлтгэх
C. Био нойл хэрэглээнд нэвтрүүлэх
D. Гэрийн мод, тавилга хийх
E. Алтыг гар аргаар олборлох

32. Хүн амын ихэнх хувийг 0-30 насны хүн ам эзэлдэг, ирээдүйд хүн ам нь өсөх чиг хандлагатай, хүйсийн тэнцвэрт байдлаа хадгалсан улсыг сонгоно уу. /2 оноо/



33. Иргэн Бат шинэ байр худалдаж авч, хотын захын хорооллоос хотын төвд нүүж ирэв. Энэ нь хот төлөвлөлтийн “Орон сууцаа сайжруулж буй бүс”-д хамаарах тул олон цөмт загварын аль тоон утгад тохирох вэ? /2 оноо/



34. Өгөгдлийг уншаад эрчим хүчний гол эх үүсвэр нь байгалийн ямар нөхцлөөс шалтгаалсан болохыг тодорхойлно уу. /2 оноо/

Тайширын усан цахилгаан станц нь жилдээ 35 кВт/ц эрчим хүчийг үйлдвэрлэх чадалтай. Говь-Алтай болон Завхан аймгуудын зарим сумдыг эрчим хүчээр хангадаг. Тогтмол эрчим хүчийг авдаг, агаарын бохирдол үүсгэхгүй, байгалийн эх үүсвэр юм.

- A. Урсац нь тогтвортой жилийн туршид урсдаг гол
- B. Хөндий хотгорын төвийн чийг намагтай гадарга
- C. Салхины хурд тогтвортой талархаг гадарга
- D. Нарны тусгал болон ууршилт ихтэй ээвэр гадарга
- E. Түр зуурын урсгалтай, үе үе огцом үерлэдэг гол

35. Тээврийн төрлүүдийг сул талуудтай нь харгалзуулна уу. /2 оноо/

№	Тээврийн төрлүүд		Сул тал
1	Агаарын тээвэр	а	Холын зайд удаан, цаг агаарийн нөхцлөөс хамаарна
2	Усан замын тээвэр	б	Тав тух муутай, барьж байгуулахад өртөг өндөр
3	Авто замын тээвэр	в	Өртөг өндөр, цаг агаарын нөхцлөөс хамаарна
4	Төмөр замын тээвэр	г	Бага хэмжээний ачааг тээвэрлэнэ, холын зайд удаан.

A. 1а, 2г, 3в, 4б

B. 1г, 2б, 3а, 4в

C. 1в, 2а, 3г, 4б

D. 1в, 2б, 3г, 4а

E. 1б, 2а, 3в, 4г

36. Хэрэв чи Канад улсын Оттава хотод суралцахаар явж байгаа гэж төсөөлье. Тэнд газарзүйн бүсийн ямар орчинтой байх вэ? /2 оноо/

- A. Халуун хуурай, агаарын их даралтын мужид оршдог. Пассат салхи зонхилдог. Өвөл $+10^{\circ}\text{C}$ -ээс буурахгүй, зундаа дунджаар $+30^{\circ}\text{C}$ - $+35^{\circ}\text{C}$. Саванн, цөл, халуун орны ойтой.
- B. Баруун зүгийн салхины нөлөөнд оршино. Далайн эргээр чийглэг, эх газрын төв хэсгээр хуурай, тайга, хээр, цөл, холимог ойтой. 1-р сард -10°C орчим, 7-р сард $+25^{\circ}\text{C}$, дунджаар 180-200 мм орчим тунадас унадаг.
- C. Дулаан ба чийгийн хувьд улирлын ялгаа байхгүй. Чийглэг, мөнх ногоон ойтой, жилийн туршид $+25^{\circ}\text{C}$ - $+30^{\circ}\text{C}$, дунджаар 2000 мм түүнээс их тунадас унадаг.
- D. 7-р сард $+10^{\circ}\text{C}$ хүрэхгүй, өвөлдөө -40°C , дунджаар 50-100 мм орчим тунадас унадаг. Дулаан дутагдалтай учир ууршилт бага, цэвдэг, намаг элбэг тархсан.
- E. Хамгийн дулаан сардаа $+5^{\circ}\text{C}$ орчим ба түүнээс бага температуртай. Дээд ургамалгүй, хаг, хөвд ургана, үргэлжилсэн цэвдэгтэй, дунджаар 5-30 мм орчим тунадас унадаг.

37. Монгол Улс Парисын хэлэлцээрийг УИХ-аар хэлэлцэн 2016 онд соёрхон баталсан. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад бидний зүгээс оруулах хувь нэмэрт тохирох хариултыг олно уу. / 2 оноо/

A. Гар утсаараа тоглож, тогтмол цэнэглэх


B. Аяга тавгаа угаахдаа усанд тосож угаах

C. Зурагтаа залгуураар нь салгаж унтраах

D. Бензин хөдөлгүүртэй машин сонгож унах

E. Крантаа дутуу хааснаас байнга ус дуслах

38. Хүн ам нь ундны усны хомсдолд орсон Ази тивийн улсуудыг сонгоно уу. /2 оноо/



A. Афганистан, Камбож, Лаос
C. Лаос, Перу, Индонез
E. Ирак, Румын, Пакистан

B. Саудын Араб, Этиоп, Энэтхэг
D. Камбож, Филиппин, Мавритан

39. Африк болон Евразийн хавтангууд 1 жилд 5 см орчим ойртон нийлдэг бол 1 сая жилийн дараа хэдэн км зайтай ойртохыг тооцоолно уу. /2 оноо/

A. 0.5 км B. 500 км C. 5000 км D. 50 км E. 5 км

40. Монгол оронд ирсэн АНУ-ын иргэнд өнөөдөр агаарын температур $+30^{\circ}\text{C}$ гэдгийг фаренгейтийн хуваариар хэд гэж ойлгуулах вэ? ($t^{\circ}\text{F}=9/5t^{\circ}\text{C}+32$) /2 оноо/

A. 62°F B. 49°F C. 86°F D. 34°F E. 32°F

41. Хуурай газар ба усны харилцан адилгүй халж, хөрдөг зүй тогтлоос болж өдөр, шөнөөр чиглэлээ өөрчилдөг орон нутгийн салхины шөнийн чиглэлийг тодорхойлно уу. /2 оноо/



A. Нуураас эрэг рүү чиглэнэ B. Эргээс нуур луу чиглэнэ
C. Далайгаас эх газар луу чиглэнэ D. Эх газраас далай руу чиглэнэ
E. Мэлхийн замаас экватор луу чиглэнэ

42. Туул гол Хэнтий нурууны өвөр (д.т.д 1850 м)-өөс эх авч 819 км урсаад Орхон гол (д.т.д 780 м)-д цутгадаг бол голын уналыг тооцоолно уу. ($H=N_1-N_2$) /2 оноо/

A. 2630 м B. 1031 м C. 1599 м D. 1070 м E. 2669 м

43. Говийн бүсэд Заг модыг ургуулахад хамгийн тохиромжтой хөрсийг сонгоно уу. /2 оноо/

A. Элсэрхэг хөрс, Сульфат, натриар баялаг, 2-3% ялзмагт хөрс
B. Улаан хүрэн, Төмөр, хөнгөн цагааны исэл их, 3-5% ялзмагт хөрс
C. Цайвар саарал, Карбонат, шохой, давс их, 0.2-0.5% ялзмагт хөрс
D. Хүрэн, Кальци, магниар баялаг, 5-7% ялзмагт хөрс
E. Саарал, Цахиур, шүлтийн агууламж их, 1.5-2% ялзмагт хөрс

44. гараг нарнаас 778 сая км зайд алслагдсан байдаг. Энэ зайг одон орны нэгжээр илэрхийлнэ үү. /2 оноо/


A. Бархасбадь, 0.19 о.о.н B. Ангараг, 51.8 о.о.н C. Дэлхий, 1.00 о.о.н
D. Бархасбадь, 5.19 о.о.н E. Ангараг, 5.19 о.о.н

45. Хөгжингүй орнуудын хүн ам, бараа бүтээгдэхүүн, худалдааны хувь хэмжээг тодорхойлно уу. /2 оноо/

№	Үзүүлэлт	Хөгжингүй	Дунд зэргийн хөгжилтэй	Хөгжиж буй
1	Хүн ам	?	5%	80%
2	Бараа бүтээгдэхүүн	?	31.6%	21.4%
3	Худалдаа	?	19%	30%

- A. Хүн ам 49%, Бараа бүтээгдэхүүн 68.4%, Худалдаа 19%
 B. Хүн ам 15%, Бараа бүтээгдэхүүн 25.6%, Худалдаа 51%
 C. Хүн ам 65%, Бараа бүтээгдэхүүн 31.6%, Худалдаа 19%
 D. Хүн ам 47%, Бараа бүтээгдэхүүн 31.6%, Худалдаа 19%
 E. Хүн ам 15%, Бараа бүтээгдэхүүн 47%, Худалдаа 51%

46. Графикийг ашиглан сүүлийн 20 жилд хотжилт хэдэн хувиар өсөх хандлагатай байгааг тооцоолно уу. /2 оноо/




- A. 11.8% B. 50.8% C. 9.1% D. 89.3% E. 59.9%

47. Дэлхийн уур амьсгалын зарим бүсүүдийн онцлогийг, эрхлэх аж ахуйтай нь харгалзуулна уу. /2 оноо/

№	Уур амьсгалын бүсүүд		Бүсүүдийн онцлог		Эрхлэх аж ахуй
1	Цөлийн	А	Өвөл бага зэрэг хүйтэн, зун нь чийглэг, халуун	а	Нэрс
2	Газар дундын тэнгисийн	Б	Хуурай, өдөр, шөнийн температурын зөрүү их	б	Хасарваань
3	Өндөр уулын	В	Жилийн туршид хуурай, халуун	в	Усан үзэм

- A. 1Б6, 2Ав, 3Ба B. 1А6, 2Бв, 3Ва C. 1Бв, 2Ва, 3Б6
 D. 1Ба, 2Вв, 3А6 E. 1Бв, 2А6, 3Ва

48. Дэлхий дээрх хоёр цэгийн хоорондох хамгийн богино буюу дөт агаарын зам нь дэлхийн бөмбөрцгийн их тойргийн нумын дагуу тодорхойлогдоно. Лос-Анжелос хотоос Сөүл хот руу шууд нислэг хийхэд аль зүг рүү хөөрвөл илүү дөт зам байх вэ? /2 оноо/




- A. Зүүн өмнөд зүг рүү B. Зүүн хойд зүг рүү C. Баруун өмнөд зүг рүү
D. Баруун хойд зүг рүү E. Өмнөд зүг рүү

49. Африкийн Сахарын цөлд жилд 50 мм тунадас унах бөгөөд уурших чадвар нь 2250 бол чийглэг байдлыг тооцоолоорой. ($K=r/E$. r -тунадасны нийлбэр, E -уурших чадвар) /2 оноо/

- A. 0.4 B. 0.2 C. 0.02 D. 4.5 E. 0.22

50. Монгол орны гадаргын усны нөөц хамгийн багатай аймаг болон хамаарах гол мөрдийн ай савыг зөв тодорхойлсон хариултыг сонгоно уу. /2 оноо/



- A. Завхан-Номхон далайн ай сав B. Өмнөговь-Төв Азийн гадагш урсгалгүй ай сав
C. Ховд-Төв Азийн гадагш урсгалгүй ай сав D. Дорнод-Номхон далайн ай сав
E. Өвөрхангай-Хойд мөсөн далайн ай сав

ХОЁРДУГААР ХЭСЭГ

САНАМЖ:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзаа /хариу, бодолт/-г зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл: Бодлогын хариу 1234 гарсан гэж үзвэл $a=1$ $b=2$ $c=3$ $d=4$ гэж бөглөнө.
3. Хэрэв бодлогын хариу бутархай тоо байвал бодлого тус бүрийн хариултын загварын дагуу бөглөнө. Жишээлбэл: Бодлогын хариу 45.67 гарсан гэж үзвэл тухайн бодлогын хариулт бөглөх загварыг [ab.cd] гэсэн байдлаар өгсөн байна. Дээрх хариуг бөглөхдөө $a=4$ $b=5$ $c=6$ $d=7$ гэж бөглөнө.
4. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.


2.1. $3У105^0$ дээр орших А хотод баасан гарагийн 12 цаг болж байв. Тэгвэл $3У15^0$ дээр орших Б хотод ямар гарагийн хэдэн цаг болж байхыг тооцоолно уу. **/6 оноо/**

А. Цагийг тооцох [a] /4 оноо/

В. Гараг нэрлэх [b] /2 оноо/

1. Баасан 2. Лхагва 3. Даваа 4. Бямба 5. Пүрэв

2.2. Графикийг ашиглан дараах асуултад хариулна уу. **/6 оноо/**



А. 2010-2015 оны хооронд Өмнөговь аймгийн хүн ам 1 жилд хэдээр өссөн бэ? [abcd] /3 оноо/


В. Хүн ам хэдээс хэдэн оны хооронд хамгийн бага өсөлттэй байсан бэ? [e] /3 оноо/

1. 2010-2015 он 2. 1969-1979 он 3. 1979-1990 он
4. 1990-2000 он 5. 2000-2010 он

2.3. Хурган нуураас зүүн хойш Ховд голын баруун талд орших Ховд (д.т.д 2737 м) уулын оройд агаарын температур $+10^{\circ}\text{C}$ байх үед уулын бэл (д.т.д 1737 м)-д хэдэн хэм байх вэ?

/6 оноо/

Агаарын температур 100 м өндөрсөх тутамд 0.6°C -ээр буурна.



A. Агаарын температур

[ab] $^{\circ}\text{C}$

/2 оноо/

B. Харьцангуй өндрийг бодож олоорой.

[cdef] м

/2 оноо/

C. Хотгор гүдгэрийн хэв шинжийн аль ангилалд багтахыг сонгоно уу.

[g]

/2 оноо/

1. Өндөр уул

2. Дундаж өндөр уул

3. Нам уул

4. Цав толгод

5. Ухаа гүвээ

2.4. Далай, тэнгисийн тухай ойлголтуудыг зөв хариутай нь харгалзуулна уу?

[a], [b], [c], [d], [e], [f]

/6 оноо/

a	Далай, тэнгисийн усны түвшин тодорхой хугацаанд ихсэх үзэгдэл	1	Урсгал
b	Номхон далайг Атлантын далайгаас тусгаарладаг хоолой	2	Кариб
c	Тодорхой чиглэлд урсаж буй их хэмжээний далайн ус	3	Түрэлт
d	Өмнөд Америкийн баруун эргийн дагуу экватор луу чиглэсэн хүйтэн урсгал	4	Магеллан
e	Хойд, өмнөд Америкийн эх газрын хооронд орших Атлантын далайн тэнгис	5	Бенгал
f	Ази тивийн өмнөд хэсэгт мэлхийн замын шугамын ойролцоо орших булан	6	Энэтхэг
		7	Перу